

## **МБСХ-НЫ ЗӨВШӨӨРӨГДСӨН БҮЖИГ БА ХӨДӨЛГӨӨНҮҮДИЙН ТУХАЙ ДҮРЭМ**

### **1. ҮНДСЭН ЖУРАМ**

1.1. Энэхүү журмыг МБСХ-ны Тэргүүлэгчдээс боловсруулж, 2004 оны 8-р сарын 15-нд батлав. Дүрэм нь 2004 оны 10-р сарын 1-нээс мөрдөгдөнө. МБСХ-ны гишүүд жил бүрийн 4-р сараас 8-р сар хүртэл энэхүү журамд нэмэлт ба өөрчлөлт оруулах саналаа өгөх эрхтэй.

1.2. Энэхүү журам нь МБСХ-ны бүх бүтцэд хэрэгжих ёстой. Журмыг тэмцээний үндсэн цогц элемент болох клубын тэмцээнээс эхлээд Монгол улсын аварга шалгаруулах, цомын тэмцээн хүртэлх МБСХ-ны тэмцээний бүх төрөл, хэлбэр, шатанд хэрэглэнэ.

1.3. Энэхүү журмыг клубуудад хүргэх, сурталчлах, дүрмийг бүсийн тэмцээнээс эхлээд клубын тэмцээнүүдэд нэн даруй хэрэглэх нь гишүүн байгууллагуудын Тэргүүлэгчдийн үүрэг мөн.

1.4. Энэхүү журмыг бүх насны ангилалын хос бүрд хүргэх, журмыг клубын тэмцээнүүдэд хэрэглэх нь тухайн клубын удирдлага, дасгалжуулагчийн үүрэг мөн.

1.5. МБСХ-ны ба/эсвэл гишүүн байгууллагуудын албаны хүмүүс энэхүү журмыг хэрэгжүүлэх үүргээ үл биелүүлбэл МБСХ-ны Тэргүүлэгчид сахилгын арга хэмжээ авах эрхтэй.

1.6. Тэмцээний үед энэхүү журам хэрэгжиж байгаа эсэхэд ерөнхий шүүгч хяналт тавих үүрэгтэй. Харин түүний эзгүйд тэмцээний зохион байгуулагч хяналт тавина.

1.7. Дүрэм зөрчсөн явдал илэрвэл ерөнхий шүүгч нь тамирчинд урьдчилан сануулж, тамирчин ба түүний дасгалжуулагчийг тэмцээн эхлэхээс өмнө зөрчлөө арилгахыг шаардах үүрэгтэй. Хэрэв тамирчин шаардлагыг үл биелүүлбэл ерөнхий шүүгч түүний гүйцэтгэх эрхийг тухайн тэмцээнийг дуустал хасах эрх эдэлнэ.

1.8. Клубын тэмцээнээс эхлээд бүсийн тэмцээнүүдэд гүйцэтгэх эрхийг хассан тохиолдол бүрийг ерөнхий шүүгч тухайн клубын удирдлага болон МБСХ-ны Тэргүүлэгчдэд бичгээр мэдээлэх үүрэгтэй.

1.9. Тамирчин эсвэл түүний клубын удирдлагаас гүйцэтгэх эрхийг хассан албан тушаалтны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд гомдол мэдүүлснээс хойш 14 хоногийн хугацаанд МБСХ-ны Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцэнэ. Энэхүү хурлын шийдвэр эцсийнх байна.

### **1. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ, ҮНДСЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ ЗҮЙЛС БА ХЯЗГААРЛАЛТ**

#### **2.1. БҮЖГҮҮД**

2.1.1. Хөтөлбөрийн бүтэц. Албаны баримт болон амаар зарлахад ашиглахыг зөвшөөрсөн нэр томъёо ба товчилсон үгс:

2.1.1.1 Стандартын хөтөлбөр – Стандартын бүжгүүд – Стандарт – СТ – ST

Удаан вальс	Англи вальс	Вальс	- УВ эсвэл В эсвэл W
Танго			- Т
Венийн вальс			- ВВ эсвэл V
Удаан фокстрот			- УФ эсвэл F
Хурдан фокстрот	Квикстеп		- ХФ эсвэл Q

2.1.1.2 Латины хөтөлбөр – Латин бүжгүүд – Латин – ЛА – LA

Самба			- С эсвэл S
Ча ча ча			- Ч эсвэл Ch
Румба			- Р эсвэл R
Пасодобль			- П эсвэл P
Жайв			- Ж эсвэл J

- 2.1.2. Зөвшөөрөгдсөн тоо хэмжээ ба бүжгүүдийг гүйцэтгэх дараалал
- |  |           |                                  |
|--|-----------|----------------------------------|
| “E” зэрэглэл ба X-1 ангилалд           | 6 бүжиг:  | УВ, ВВ, ХФ, С, Ч, Ж              |
| “D” зэрэглэл ба X-2 ангилалд           | 8 бүжиг:  | УВ, Т, ВВ, ХФ, С, Ч, Р, Ж        |
| “C” зэрэглэл ба X-2-оос бусад ангилалд | 10 бүжиг: | УВ, Т, ВВ, УФ, ХФ, С, Ч, Р, Ц, Ж |

Бусад бүх тусдаа зэрэглэл ба ангилалуудад:

Латины хөтөлбөр	5 бүжиг:	С, Ч, Р, Ц, Ж
Стандартын хөтөлбөр	5 бүжиг:	УВ, Т, ВВ, УФ, ХФ

6, 8, 10 бүжгийн тэмцээн дээр финал нь стандартын хөтөлбөрөөр эхэлнэ.

Бүх тэмцээн дээр нэг ангилалын хагас финал ба финал нь нэг өдөр нэг байранд явагдах ёстой.

- 2.1.3. Хөгжмүүдийн тоглогдох үргэлжлэх хугацаа ба тоглогдох хөгжим

УВ, Т, УФ, ХФ, С, Ч, Р бүжгүүдэд	1,5 минут
----------------------------------	-----------

ВВ, Ж бүжгүүдэд	1 минут
-----------------	---------

Тусгай тохиолдолд зөвхөн ерөнхий шүүгчийн зөвшөөрлөөр хөгжмүүдийн тоглогдох хугацааг өөрчлөхийг зөвшөөрнө.

X-1, X-2 ангилалын хосуудын гүйцэтгэлийн үед бүжгүүдийн хөгжмийг зөвхөн зэмсгээр тоглосон байх ёстой. Дуулаачны хоолойтой хөгжмийг зөвшөөрөхгүй.

- 2.1.4. Бүжгүүдийн хөгжмийн зөвшөөрөгдөх хэмнэл (минутан дахь тактын тоо):

Вальс	28-30такт/мин	Самба	50-52такт/мин
Танго	31-33такт/мин	Ча-ча-ча	30-32такт/мин
Венийн вальс	58-60такт/мин	Румба	25-27такт/мин
Удаан фокстрот	28-30такт/мин	Пасодобль	60-62такт/мин
Хурдан фокстрот	50-52такт/мин	Жайв	42-44такт/мин

- 2.1.5. Бүжгүүдийг хасах ба пасодоблийн хөгжмийг хураангуйлах

ОУБСХ-ны Дүрмээс хамааран IDSF нээлттэй ба хаалттай тэмцээнүүдэд бүжгүүдийг хасах ба пасодоблийн хөгжмийг хураангуйлахыг зөвшөөрөхгүй.

Монгол улсын аварга шалгаруулах, цомын тэмцээнүүдийн зөвхөн анхан шатны шалгаруулалт ба редансийн үед бүжгүүдийг хасах ба пасодоблийн хөгжмийг хураангуйлахыг зөвшөөрнө.

Бүх урсгал тэмцээнүүдийн 1/4 финалаас бусад бүх сонгон шалгаруулах даваануудад бүжгүүдийг хасахыг зөвшөөрнө.

Бүх тэмцээнүүдийн хагас финал ба финалд пасодоблийн хөгжмийг хураангуйлахыг зөвшөөрөхгүй.

*Бүжгүүдийг хасах зөвшөөрөгдсөн тоо:*

10, 8, 6 бүжгээс – хөтөлбөр бүрээс нэг бүжгийг

5 бүжгээс – нэгийг.

*Хасахыг зөвшөөрсөн бүжгүүд:*

Зэрэглэлийн тэмцээнүүд	Насын ангилалын тэмцээнүүд	Бүжгүүд
“E”, “D”	X-1, X-2	ВВ ба Ж
“C”, “B”, “A”, “S”, “M”	Ө-1, Ө-2, 3, НХ, Ах	ВВ эсвэл ХФ, П эсвэл Ж

Хоёр даваанд дэс дараалан нэг бүжгийг хасахыг зөвшөөрөхгүй.

Бүжгүүдийг хасах ба хөгжмийг хураангуйлахыг зөвхөн ерөнхий шүүгч зохион байгуулагчийн хүсэлтээр шийдвэрлэнэ.

## 2.1. ХӨДӨЛГӨӨНҮҮД

Бүх ур чадварын зэрэглэлүүдэд өргөлтийг гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй

ОУБСХ-ны Дүрэмд заагдсанаар Өргөлт бол партнерийнхаа дэмжлэг тусламжтайгаар бүжигчний хоёр хөл шалнаас ижил хугацаагаар өргөгдөх хөдөлгөөн эсвэл байдал юм.

“E”, “D”, “C” зэрэглэлүүдэд поз (line), үсрэлт, Grand Battement, Developpe, Attitude, Grand Rond, доогуур таталтыг зөвшөөрөхгүй. Kick ба flick хэлбэрийн шидэлтүүдийг зөвхөн хөлөө 45 градуссаас өндөргүйгээр гүйцэтгэж болно.

“E”, “D” зэрэглэлүүдэд зөвхөн 1 ба 2-р хавсралтад заагдсан хөдөлгөөнүүдийг ижилссэн техник ба хэмнэлээр гүйцэтгэнэ.

Латин бүжгүүдэд 4 тактаас (жайвд 6) илүүгүй хугацаагаар гараа барилгүйгээр бүжиглэхийг зөвшөөрнө.

Ча ча ча бүжигт шассений оронд “D” зэрэглэлд Ronde Chasse, Hip Twist Chasse, Slip Chasse “C” зэрэглэлд Crossover Chasse, Ronde Close Chasse, Three Step Turn бүжиглэж болно.

Ча ча ча бүжигт “D” зэрэглэлд Close Basic, Check “C” зэрэглэлд Time Step, Fan, Turkish Towel, Cross Basic-ийг “гуапача” хэмнэл дээр бүжиглэж болно.

Жайв бүжигт “D” зэрэглэлд Ball Change-ийн оронд “фликүүд”, “C” зэрэглэлд шассен оронд Single Step, Double Step-ийг бүжиглэж болно.

Бүх Латин бүжгүүдэд “C” зэрэглэлд тухайн бүжигт тохирсон төрөл бүрийн байрлалуудын хөдөлгөөнүүд ба гарын байрлалуудыг ашиглаж болно. Жишээлбэл, самбад Travelling Volta, Circular Volta, Bota Fogo, Corta Jaca, Cruzado Locks, Roll-ийн сүүдэр байрлал, ча ча чад Open Basic, Close Basic, Time Step-ийг “гуапача” хэмнэл дээр, Ronde Chasse, Cuban Break, Split Cuban Break бүжиглэж болно.

Стандартын бүжгүүдэд “C” зэрэглэлд хөдөлгөөнүүдийн элементүүдийг нэгтгэх, эрэгтэй эмэгтэйн алхалтуудыг, эмэгтэй эрэгтэйн алхалтуудыг гүйцэтгэхийг зөвшөөрнө. Мөн бусад стандартын бүжгийн хөдөлгөөнүүдийг бүжиглэхийг зөвшөөрнө.

Өсвөр-II, Залуучууд, Насанд хүрэгчид, Ахмадуудын E, D, C зэрэглэл хязгаарлалт байхгүй.